ТӨӨЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: 20% Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: 20%
ТӨӨЗ 42.1, 42.2	Гүйцэтгэлийн баталгааны дүн: Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх дүнтэйгээр ирүүлнэ.

Handwritten notes and stamps in Mongolian script, including a red rectangular stamp with the number 1116 127152.

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2017 оны 1189 Одүгээр
тушаалын хавсралт



ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ хэсэг нь ТӨӨЗ-ны хэсэг бөгөөд захиалагч ТШӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээг хийхдээ тендерийн маягтанд тусгасан үнийн саналаас гадна ТӨӨЗ-ын 35.2 (г)-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж болох бөгөөд ингэхдээ дараах шалгуур болон аргачлалыг ашиглан мөнгөөр илэрхийлж, тендерийн маягтад дурдсан үнэд харгалзан тооцсоны үндсэн дээр тендерийн харьцуулах үнийг гаргана. Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

- (а) Гэрээний болон арилжааны зөрүү: “Ашиглахгүй”
- (б) Бараа нийлүүлэлтийн хуваарь: “Ашиглахгүй”
- (в) Тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ний үр ашиг болон үйл ажиллагааны баталгаа: “Ашиглахгүй”
- (г) Тусгайлсан нэмэлт шалгуур: “Ашиглахгүй”

Олон багцтай тендерийг үнэлэх

ТӨӨЗ-ны 35.6-д заасны дагуу захиалагч нэг ба түүнээс дээш багцаар гэрээ байгуулах эрхтэй бол олон багцыг үнэлж гэрээ байгуулах эрх олгоход дараах аргачлалыг мөрдөнө.

Захиалагч багцуудын хамгийн сайн үнэлэгдсэн буюу хамгийн үр ашигтай байх хувилбарыг дараах байдлаар сонгоно. Үүнд:

- (а) ТӨӨЗ-ны 15.8-д зааснаар багц тус бүрт байх барааны нэр төрөл болон нэр төрөл тус бүрийн тоо хэмжээ нь бүрэн бол тухайн багцад үнэлгээ хийнэ.
- (б) Үнэлгээнд дараах журмыг баримтална:
 - (i) багц тус бүрт үнэлгээний шалгуурыг хангасан хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тогтоох;
 - (ii) тендерт оролцогчийн тухайн хамгийн сайн үнэлэгдсэн тендерт санал болгосон үнийн хөнгөлөлтийг санал болгосон аргачлалын дагуу багц тус бүрт тооцох;
 - (iii) эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байх хувилбараар гэрээ байгуулах эрх олгохоор сонгох. Ингэхдээ нэг тендерт оролцогч 2 ба түүнээс дээш багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн бол түүний гэрээг хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаж тогтооно. Хэрвээ тухайн оролцогч 2-оос дээш багцад гэрээ хэрэгжүүлэх чадвар нь хангалтгүй гэж үнэлэгдвэл түүний чадавхид тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 119 дугаар туувааны хэсэрт

ЖАГСААЛТ, ТОО ШИРХЭГ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

ЭХЭГ, ҮНЭМЛЭХ БАГЦ №00УБЕГ/201703

№	Үнэт цаасны төрөл маягт, тодорхойлолт		Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх хамгийн эцсийн хугацаа
	Иргэний бүртгэл	Хатуу дугаар, нууцлал бүхий				
1.1	Төрсний гэрчилгээ	хатуу дугаар, нууцлал бүхий	100,000	ширхэг	2017.06.09	2017.06.28
1.2	Гэрлэлтийн гэрчилгээ	хатуу дугаар, нууцлал бүхий	20,000	ширхэг	2017.06.09	2017.06.28
1.3	Гэрлэлт цуцласны гэрчилгээ	хатуу дугаар, нууцлал бүхий	4,400	ширхэг	2017.06.09	2017.06.25
1.4	Нас барсны гэрчилгээ	хатуу дугаар, нууцлал бүхий	14,000	ширхэг	2017.06.09	2017.06.25
1.5	БНХАУ-д хил зорчих үнэмлэх /нэг удаа/	хатуу дугаар, нууцлал бүхий	7,000	ширхэг	2017.06.09	2017.06.25
1.6	БНХАУ-д хил зорчих үнэмлэх /олон удаа/	хатуу дугаар, нууцлал бүхий	15,000	ширхэг	2017.06.09	2017.06.25
1.7	МО-ын хилийг цааш нааш нэг удаа нэвтрэх эрхийн үнэмлэх	хатуу дугаар, нууцлал бүхий	70,000	ширхэг	2017.06.15	2017.06.25
2.1	Эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ Y-2	Эд хөрөнгийн бүртгэл	90,000	ширхэг	2017.06.09	2017.06.25
2.2	Газар өмчлөх эрхийн гэрчилгээ Y-2	хатуу дугаар, нууцлал бүхий	65,000	ширхэг	2017.06.15	2017.06.25
3.1	Улсын бүртгэлийн гэрчилгээ /А4/	Хуулийн этгээдийн бүртгэл	15,000	ширхэг	2017.06.09	2017.06.25
	НИЙТ		400,400			

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

Тендер шалгаруулалтын маягтыг бөглөх санамж

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендерийн маягт, үнийн хуваарийг бөглөж, энэ бүлэгт заасан маягтаар гаргасан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Арифметик алдаа, хүлээн зөвшөөрөгдөх зөрүү (төлбөрийн хуваарь, барааг хүргэх хуваарь гэх мэт), сэлбэг болон барааны тоо ширхэгийг тендерийн баримт бичгийн дагуу залруулж, өөрчилсний дараа гэрээний маягтад гарын үсэг зурна.

Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

УХА0582
5296722
1116.127158

ТЕНДЕРИЙН МАЯГТ



(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэрийг оруул], энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн [бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]-г [тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш [тоо] хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт [үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул] үзүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



МАЯГТ №: ТШМ-2А

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(А ангилал)

Огноо: _____
 НТШ-ын дугаар: _____
 Тендерийн урилгын дугаар: _____
 Хувилбарт тендерийн дугаар: _____
 Хуудасны _____-ын _____ дугаар _____

ТӨӨЗ-ны 16-д заасан валцогоор

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны толорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXW бүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодлын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 15.9.(а),(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд, болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэххувь	ТӨӨЗ-ны 15.9.(а),(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад тагвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
Тендерийн нийт үнэ (10)									

Тендэрт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МАЯГТ №: ТШМ -2Б



**3. ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(БАНКНЫ БАТАЛГАА)**

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Банкны нэр]* (цаашид “Банк” гэх) нь *[Захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*-ийн¹ төлбөр хийх үүрэг хүлээж баглан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь *[огноог оруул]* өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹ Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Баталгааны мөнгөн дүн нь ТӨӨЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

Огноог оруулахдаа ТӨӨЗ-ны 21.3-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна.

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулагчийн нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН, УХА0582, 16 127152



Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн бирж] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн² төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн засгийн газрын бондыг³ үндэслэн батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (2) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (3) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлдээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ.

Энэхүү баталгаа нь [огноог оруул]¹¹ өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж биржид мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Биржийн тамга

Огноо:

Хаяг:

² Баталгааны дунг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дун нь ТООЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

³ Засгийн газрын бондын эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

¹¹ Огноог оруулахдаа ТООЗ-ны 21.3-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна.



МАЯГТ №: ТШМ-4

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагч ~~аар~~ энэ маягтыг бөглүүлсэн байна. Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан ёсоор дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]
НТШ-ын дугаар: [оруул: тендер шалгаруулалтын дугаар]
Хувилбарын дугаар: [оруул: энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]-д байршилтай [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр] нь [оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр [оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр] компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан [оруул: барааны нэр ба товч тодорхойлолт], барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

5. Чадварын мэдээлэл ирүүлэх маягтууд



Санал болгож буй туслан гүйцэтгэгч

Зүйл	Туслан гүйцэтгэгчийн нэр	Бүртгэгдсэн газар болон чадавхи



Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

1.	Гэрээний дугаар	
	Гэрээний нэр	
	Улсын нэр	
2.	Захиалагчийн нэр	
3.	Захиалагчийн хаяг	
4.	ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог	
5.	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн	
6.	Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна) Мөнгөний нэгж Мөнгөний нэгж Мөнгөний нэгж	
7.	Гэрээний дүн: _____; Туслан гүйцэтгэх гэрээ: _____; Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _____;	
8.	Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо	
9.	Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах)	
10.	Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах)	
11.	Техникийн тусгай шаардлагууд.	
12.	Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах.	

МАЯГТ №: ТНМ-5В
 1148 2152
 УХА0582

Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо түйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ. Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Санхүүгийн чадавхи

МАЯГТ №: ТШМ-5Г
 ᠮᠣᠩᠭᠣᠯ
 ᠪᠠᠨᠭᠠᠨ
 ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠭᠢᠨ
 ᠴᠢᠳᠠᠪᠬᠢ
 ᠮᠠᠶᠢᠭᠲᠤ
 ᠨᠡᠭ

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТӨӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албанд гушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

Банк	Банкны нэр	
	Банкны хаяг	
	Утас	Холбоо барих ажилтны нэр, албан тушаал
	Факс	Телекс

Сүүлийн (ТШӨХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монгол банкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /сая/	Сүүлийн (ТШӨХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацаанд					Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд	
	5	4	3	2	1	1	2
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өглөг							
4. Эргэлтийн өглөг							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТӨӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр	Дун
1.	
2.	
3.	
4.	

ТӨӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

МАЯГТ №: ТЦМ-5Д

Ажиллах хүчний чадавхи

Тендерт оролцогчийн нэр

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

1.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
2.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
3.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
4.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ТАВДУГААР БҮЛЭГ

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

АГУУЛГА

1. БАРААНЫ НЭР ТӨРЛИЙН ЖАГСААЛТ БОЛОН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ
2. ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ
3. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
4. ЗУРАГ ТӨСӨЛ
5. ШАЛГАЛТ БОЛОН ТУРШИЛТ



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2017 оны 139 Одүгээр
тушаалын хавсралт



2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үнэт цаас, маягт нь дараах техникийн тодорхойлолтод заасан өнгө, хэмжээ болон стандартыг бүрэн хангасан байна.

Үнэт цаас, маягтын доторх бичвэр, дугаарлалтыг гэрээ байгуулах эрх олгох үед нийлүүлэгчид мэдэгдэнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ХУРААНГУЙ

Дугаар	Үнэт цаас,, маягтын нэр	Үнэт цаас, маягтын баглаа боодол, дугаартай эсэх
1	Төрсний гэрчилгээ	Цаас, хуудасгүй, 500-1000 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 10 оронтой байна
2	Гэрлэсний гэрчилгээ	Цаас, хуудасгүй, 500-1000 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 10 оронтой байна
3	Гэрлэлт иуцлалтын гэрчилгээ	Лидринэн хавтас, цаас, хуудасгүй, 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 10 оронтой байна
4	Нас барсны гэрчилгээ	Лидринэн хавтас, цаас, хуудасгүй, 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 10 оронтой байна
5	БНХАУ-д хил зорчих үнэмлэх /нэг удаа/	Цаас 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 7 оронтой байна.
6	БНХАУ-д хил зорчих үнэмлэх /олон удаа/	Цаас 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 7 оронтой байна
7	МО-ын хил зорчих үнэмлэх	Цаас 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 7 оронтой байна
8	Эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ	Цаас 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 9 оронтой байна.
9	Газар өмчлөх эрхийн гэрчилгээ	Цаас 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 9 оронтой байна.
10	Улсын бүртгэлийн гэрчилгээ /4/	Цаас 100 ширхгээр багцалж, эхний болон сүүлчийн хатуу дугаарыг тэмдэглэсэн цаасаар ороосон, дугаарлалт 9 оронтой байна

1. Төрсний гэрчилгээ

Гэрчилгээний хэмжээ: Дэлгэмэл хэмжээ нь 210x297 /A4/ мм хэмжээтэй.

Цаас: Черниль болон балаар бичилт хийх, тамга тэмдгийн дардас тогтвортой байх бичгийн зориулалттай офсетын 120гр/м² нягттай үнэт цаасны зориулалтын цаас байна.

Гэрчилгээний дотор тал: Тасралтгүй үргэлжлэх 2 зураасан шугамын вектор графийн аргыг ашиглан сүлжилдсэн хээг бүтээсэн. Түүн дээр 2 захаасаа төв рүүгээ долгионд жижгэрсэн “ТӨРСНИЙ ГЭРЧИЛГЭЭ” гэсэн бичил бичвэрийг тодорхой хэмнэлтэйгээр байрлуулсан байна. Эдгээр харагдах байдлыг буй болгож байгаа зурааснууд нь хуулбарлагдах болон хуурамчаар үйлдэх тохиолдолд шугамнууд нь тасарч эвдрэх, сканердахын эсрэг хамгаалалт хийгдэнэ.

Гэрчилгээний голд билэгдлийн чанартай зан үйлийн зориулалттай нярай хүүхдийн тоглоомыг тусгай үнэт цаасны программыг ашиглан дэвсгэр хээндээ уусгаж өгсөн.

Нууцлал: Гэрчилгээний дэвсгэр хээний гол дахь босоо долгионд хээний хүрээгээр болон голоор 3 эгнээ болгон “Төрсний гэрчилгээ” гэсэн бичил бичвэрийг долгионтуулан байрлуулсан. Энэхүү бичил бичвэр нь хуулбарлагдах болон хуурамчаар үйлдэх тохиолдолд тасран эвдэрч өөрийн хэв шинжээ алдан уншигдахгүй болно.

Гэрчилгээний дэвсгэр хээний голын доод хэсэгт хагас дугуй хэлбэрээр тасралтгүй үргэлжлэх 2 зураасыг тусгай программын аргаар цэцгэн хээг бүтээсэн.

“Төрсний гэрчилгээ” гэсэн бичиглэл долгионтсон хэлбэрээр богино долгионы 366 нм-ийн UV гэрэлд улаан, 254нм-ийн UV гэрэлд ногооноор харагдана.

Баркод: Гэрчилгээний зүүн доод буланд 60x18мм-ийн хэмжээтэй цагаан талбайд Code39 үсгийн фондтой 10рт-ийн өндөртэй баркод байрлана. Баркодын зураасын өндөр 11мм, түүний доор 1мм-ийн зайд 2мм-ийн өндөртэй 10 оронтой тоон шрифт бичигдэх ба эхлэл төгсгөлд нь шалгахад зориулж * тэмдэг хийсэн. Баркод нь сканнердахад гэрчилгээний дугаар компьютерт шууд орохоор хийгдэнэ.

Дугаарлалт: Тэмдэг бүр нь давтагдашгүй дараалах 10 оронтой дугаартай байна. Дугаарлалтын зурлага болон хэмжээ нь үнэт цаасны зориулалтаар Англид үйлдвэрлэгдсэн. Дугаарыг нэвчилтэй хар будгаар хэвлэх ба ашиглалтын явцад улаанаар эмжигдэн тэлэгдэж нэвчилт явагдахаас гадна цаасныхаа ар руу улаанаар нэвчинэ.

2. Гэрлэсний гэрчилгээ

Гэрчилгээний хэмжээ: Дэлгэмэл хэмжээ нь 210x297 /A4/ мм хэмжээтэй.

Цаас: Черниль болон балаар бичилт хийх, тамга тэмдгийн дардас тогтвортой байх бичгийн зориулалттай, 120гр/м² нягттай үнэт цаасны зориулалтын цаас байна.

Гэрчилгээний дэвсгэр хээ: Тасралтгүй үргэлжлэх 2 зураасан шугамыг үнэт цаасны тусгай программыг ашиглан үндэсний хээг бүтээсэн. Түүн дээр А, Б талд голлуулан Хаан бугуйвч, Хатан сүйх билэгдлийг програмчлан дүрсэлтсэн. Эдгээр харагдах байдлыг буй болгож байгаа зурааснууд нь хуулбарлагдах болон хуурамчаар үйлдэх тохиолдолд шугамнууд нь тасарч эвдрэх, сканердахын эсрэг хамгаалалт хийгдэнэ.

Гэрчилгээний дээд, доод ирмэгээр эдгээр билэгдлүүдийг вектор графийн аргыг ашиглан тусгай програм хангамжаар боловсруулалт хийж товойлгон гаргасан.

Нууцлал: Эдгээр билэгдлийн ирмэгээр “Гэрлэсний гэрчилгээ” гэсэн бичил бичвэр тасралтгүй үргэлжлэнэ. Энэхүү бичил бичвэр нь хуулбарлагдах болон хуурамчаар үйлдэх тохиолдолд тасран эвдэрч өөрийн хэв шинжээ алдан уншигдахгүй болно.

“Гэрлэсний гэрчилгээ” гэсэн бичиглэл долгионтсон хэлбэрээр богино долгионы 366 нм-ийн UV гэрэлд улаан, 254нм-ийн UV гэрэлд ногооноор харагдана.

Баркод: Гэрчилгээний зүүн доод буланд 60x18мм-ийн хэмжээтэй цагаан талбайд Code39 үсгийн фондтой 10рт-ийн өндөртэй баркод байрлана. Баркодын зураасын өндөр 11мм, түүний доор 1мм-ийн зайд 2мм-ийн өндөртэй 10 оронтой тоон шрифт бичигдэх ба эхлэл төгсгөлд нь шалгахад зориулж * тэмдэг хийсэн. Баркод нь сканнердахад гэрчилгээний дугаар компьютерт шууд орохоор хийгдэнэ.

Дугаарлалт: Тэмдэг бүр нь давтагдашгүй дараалах 10 оронтой дугаартай байна. Дугаарлалтын зурлага болон хэмжээ нь үнэт цаасны зориулалтаар Англид үйлдвэрлэгдсэн. Дугаарыг нэвчилтэй хар будгаар хэвлэх ба ашиглалтын явцад улаанаар эмжигдэн тэлэгдэж нэвчилт явагдахаас гадна цаасныхаа ар руу улаанаар нэвчинэ.

3. Гэрлэлт цуцалсны гэрчилгээ

Гэрлэлт цуцалсны гэрчилгээ нь дэлгэсэн байхдаа 145x100 мм хэмжээтэй, голоороо буюу 72,5мм-ийн хэмжээтэй нугардаг, гадна тал нь хөх өнгийн лидринэн хавтастай, хавтасны нүүрний баруун хэсэгт дээрээсээ 11мм-ийн зайнд 3,5мм-ийн өндөртэй үсгээр “МОНГОЛ УЛС” гэсэн үгийг зүүн, баруун гараас адилхан зайнд голлож бичээд, түүнээс 11мм-ийн доор 32,5мм-ийн өндөртэй, 16мм-ийн өргөнтэй “СОЁМБО”-ыг зүүн, баруун гараас адилхан зайнд байрлуулна. Түүний доор доод талаасаа 15мм-ийн зайнд зүүн, баруун гар талаас адилхан зайтай “ГЭРЧИЛГЭЭ” гэсэн үгийг, түүнээс 3мм-ийн дээр “ГЭРЛЭЛТ ЦУЦАЛСНЫ” гэсэн үгийг тус тус 3,5мм-ийн өндөртэй үсгээр голлон бичнэ. Нүүрэнд бичигдэх бүх үсэг, соёмбо нь алтлаг холограммаар халуун даралтын аргаар буулгасан байна. Алтлаг холограмм нь дөрвөлжин талстан хээн дээр синус хэлбэрээр “Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэсэн бичил бичвэр бичигдэнэ.

Хавтасны дотор талд усан хээ бүхий хэвлэмэл цаасыг лидринэн хавтсанд наасан байх бөгөөд дотор талын нэг ба хоёр дахь хуудасны тэр хээ дотор 2 өнгөөр ууссан “Гэрлэлт цуцалсны гэрчилгээ” гэсэн нууцлал бүхий бичлэгтэй байна. Мөн “Гэрлэлт цуцалсны гэрчилгээ” гэсэн Arial Mon 7-тын хэмжээтэй, кирилл үсгээр долгионтсон хэлбэртэй, энгийн нүдэнд үл үзэгдэх бичиглэл хавтасны дотор талд дэвсгэрлэн бичигдэнэ. “Гэрлэлт цуцалсны гэрчилгээ” гэсэн бичиглэл долгионтсон хэлбэрээр богино долгионы 366 микро метрийн хэт ягаан гэрэлд улаан, 254 микро метрийн хэт ягаан гэрэлд ногооноор харагдана.

Гэрлэлт цуцалсны гэрчилгээн дотор талын нэг ба хоёр дахь хуудсанд “Иргэний бүртгэлийн тухай хууль”-ийн 14,6-д заасан бичилтийг хийсэн байна.

Гэрлэлт цуцалсны гэрчилгээний дугаар нь *0000000001-9999999999 гэсэн интервалийн дотор байх дэс дараанлсан давтагдахгүй тоо байна. Дугаарын интервалийг Улсын бүртгэлийн ерөнхий газар төрсний гэрчилгээний захиалга өгөх, хэвлүүлэх бүртгээ түүнийг хэвлэж байгаа үйлдвэрт өгнө.

Гэрлэлт цуцалсны гэрчилгээг 100 /нэг зуу/ ширхэгээр нь багцалж, түүнийг хүлээлгэн өгч байгаа хэвлэсэн үйлдвэрийн төлөөлөгч, тоолж хүлээж авч байгаа Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтны гарын үсэг бүхий шошгыг багц бүхэнд хавсаргасан байна.

Гэрчилгээний баруун дээд хэсэгт 58x18мм-ийн хэмжээтэй цагаан талбайд Code39 үсгийн фондтой 14мм-ийн өндөртэй баркод байрлана. Баркодны зураасын өндөр 11мм, түүний дотор 1мм-ийн зайд 2мм-ийн өндөртэй, 10 оронтой шрифт бичигдэх ба эхлэл төгсгөлд нь шалгахад зориулж * тэмдэг байна.

4. Нас барсны гэрчилгээ нь

Нас барсны гэрчилгээ нь дэлгэсэн байхдаа 145x100 мм хэмжээтэй, голоороо буюу 72,5мм-ийн хэмжээтэй нугардаг, гадна тал нь ногоон өнгийн лидринэн хавтастай, хавтасны нүүрний баруун хэсэгт дээрээсээ 15мм-ийн зайнд 3,5мм-ийн өндөртэй үсгээр “МОНГОЛ УЛС” гэсэн үгийг зүүн, баруун гараас адилхан зайнд голлож бичээд, түүнээс 11мм-ийн доор 32,5мм-ийн өндөртэй, 16мм-ийн өргөнтэй “СОЁМБО”-ыг зүүн, баруун гараас адилхан зайнд байрлуулна. Түүний доор доод талаасаа 15мм-ийн зайнд зүүн, баруун гар талаас адилхан зайтай “ГЭРЧИЛГЭЭ” гэсэн үгийг, түүнээс 3мм-ийн дээр “НАС БАРСНЫ” гэсэн үгийг тус тус 3,5мм-ийн өндөртэй үсгээр голлон бичнэ. Нүүрэнд бичигдэх бүх үсэг, соёмбо нь тод хар өнгөтэй байна.

Хавтасны дотор талд усан хээ бүхий хэвлэмэл цаасыг лидринэн хавтсанд наасан байх бөгөөд дотор талын нэг ба хоёр дахь хуудасны тэр хээ дотор 1 өнгөөр ууссан “Нас барсны гэрчилгээ” гэсэн нууцлал бүхий бичлэгтэй байна. Мөн “Нас барсны гэрчилгээ” гэсэн Arial Mon 7-тын хэмжээтэй, кирилл үсгээр долгионтсон хэлбэртэй, энгийн нүдэнд үл үзэгдэх бичиглэл хавтасны дотор талд дэвсгэрлэн бичигдэнэ. “Нас барсны гэрчилгээ” гэсэн бичиглэл долгионтсон хэлбэрээр богино долгионы 366 микро метрийн хэт ягаан гэрэлд улаан, 254 микро метрийн хэт ягаан гэрэлд ногооноор харагдана.

Нас барсны гэрчилгээний дотор талын нэг ба хоёр дахь хуудсанд “Иргэний бүртгэлийн тухай хууль”-ийн 19,5-д заасан бичилтийг хийсэн байна.

Гэрчилгээний дугаар нь *0000000001-9999999999 гэсэн интервалийн дотор байх дэс дараанлсан давтагдахгүй тоо байна. Дугаарын интервалийг Улсын бүртгэлийн ерөнхий газар нас барсны гэрчилгээг захиалга өгөх, хэвлүүлэх бүртгээ түүнийг хэвлэж байгаа үйлдвэрт өгнө.

Нас барсны гэрчилгээг 100 /нэг зуу/ ширхэгээр нь багцалж, түүнийг хүлээлгэн өгч байгаа хэвлэсэн үйлдвэрийн төлөөлөгч, тоолж хүлээж авч байгаа Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтны гарын үсэг бүхий шошгыг багц бүхэнд хавсаргасан байна.

Гэрчилгээний зүүн доод буланд 58x18мм-ийн хэмжээтэй цагаан талбайд Code39 үсгийн фондтой 14мм-ийн өндөртэй баркод байрлана. Баркодны зураасын өндөр 11мм, түүний дотор 1мм-ийн зайд 2мм-ийн өндөртэй, 10 оронтой шрифт бичигдэх ба эхлэл төгсгөлд нь шагхад зориулж * тэмдэг байна.

5. БНХАУ-д хил нэвтрэх үнэмлэх /нэг удаагийн/

Үнэмлэх нь дэлгэсэн байхдаа 125 мм өргөнтэй, 360мм урттай гадна талдаа "ТӨРИЙН СОЁМБО"-ыг шар өнгөөр дүрсэлсэн байх ба дотор тал нь цайвар ногоон өнгийн суурьтай, хүрээгүй 100гр/м²-ын нягттай офсет цаасаар эсхүл түүнтэй дүйцэх сайн чанарын гөлгөр биш цаасаар 4 ижил хэмжээтэй нугалахаар, нугалсан байхдаа хуудас бүрийн төвд уусмал байдлаар "ТӨРИЙН СҮЛД"-ийг шар өнгөөр оруулж хэвлэсэн, нууцлал бүхий үнэт цаастай, монгол үсэг, хятад ханзан бичвэр бүхий хэвлэмэл хуудас байна.

Хатуу дугаар хэвлэгдсэн байна Нууцлал нь хуурамчаар үйлдэгдэхээс хамгаалагдсан байх ба нэмэлт нууцлалтай байж болно.

6. БНХАУ-д хил нэвтрэх үнэмлэх /олон удаагийн/

Үнэмлэх нь дэлгэсэн байхдаа 125 мм өргөнтэй, 175мм урттай, голоороо/87.5мм/ нугарч үдэгдсэн, гадна тал нь тод цэнхэр өнгийн лидерин, бумвинил, эсхүл түүнтэй дүйцэхүйц сайн чанарын хавтастай, нүүрэнд "ТӨРИЙН СОЁМБО", түүний дээр, доор бичигдэх бүх үсэг, хятад ханз алтан шар өнгөөр дүрсэлсэн байна.

Хавтасны дотор 2 тал нь болон хуудас бүр нь нууцлал бүхий бүдэг цэнхэр өнгийн суурьтай, баруун, зүүн хэсгийн голд "ТӨРИЙН СҮЛД"-ийг шар өнгөөр дүрсэлэх ба 100 гр/м³-ын нягттай офсет цаасаар эсхүл түүнтэй дүйцэх сайн чанарын гөлгөр биш цаасаар хэвлэсэн, нууцлал бүхий үнэт цаасаар хэвлэсэн байна.

Доторхи бичвэр нь монгол үсэг, хятад ханзаар бичигдсэн байна. Хуудасны тоо 14, дугаарласан тоо нь 28 байна. Хавтас, дотор талын хуудсууд хоорондоо салахгүй бөх үдэгдсэн байна. Хуудсын булангууд гадаад паспортын адил дугуйлсан байна.

Хатуу дугаартай байна. Хатуу дугаар нь урдаа серийн үсэггүй байх бөгөөд дугаарыг эхний хуудсанд хэвлэж, мөн цоолсон байна. Цоолбор дугаар дотор талын бүх хуудас, ар талын хавтасанд тавигдсан байна. Уг цоолбор дугаар хуудсыг давхарласан байхдаа зөрөөргүй байна. Хатуу дугаарыг хувиргасан бар кодыг бичвэргүй хэсэгт байрлуулна.

Нууцлал нь хуурамчаар үйлдэгдэхээс хамгаалагдсан байх ба нэмэлт нууцлалтай байж болно.

7. Монгол, Оросын хилийг цааш нааш нэг удаа нэвтрэх эрхийн үнэмлэх

Үнэмлэх нь дэлгэсэн байхдаа 125 мм өргөнтэй, 155 мм урттай нүүрэн тал нь цагаан суурьтай, нууцлал хээний дунд "ТӨРИЙН СОЁМБО"-ыг дүрсэлсэн, дотор тал нь цэнхэр өнгийн хүрээ бүхий, 100гр/м²-ын нягттай офсет цаасаар эсхүл түүнтэй дүйцэх сайн чанарын гөлгөр биш цаасаар нугаламгүй хэвлэсэн, нууцлал бүхий үнэт цаасан дээр тод цэнхэр бичвэр бүхий хэвлэмэл хуудас байна.

Хатуу дугаар хэвлэгдсэн байна.Хатуу дугаарыг хувиргасан бар кодыг бичвэргүй хэсэгт байрлуулна.

Нууцлал нь хуурамчаар үйлдэгдэхээс хамгаалагдсан байх ба нэмэлт нууцлалтай байж болно.

8. Эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн гэрчилгээ

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /цаашид "гэрчилгээ" гэх/ нь хуурамчаар үйлдэгдэхээс хамгаалагдсан нууцлал бүхий үнэт цаас байна.

Үнэт цаас нь тусгайлсан дугаартай байх ба дугаар нь үл давхцана.

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь улаан өнгөтэй. Гэрчилгээ нь бичгийн А4 цаасны хэмжээтэй, 150 гр/м²-ийн нягтралтай, босоо хэлбэртэй байна.

Гэрчилгээ нь төрөл тус бүрээрээ 9 орноос бүрдсэн араб тоо бүхий дараалсан хэвлэмэл дугаартай, хуудасгүй байна.

Гэрчилгээний 4 талын ирмэгээс 5 мм зайд тодорхой давтамжтай долгионтуулсан зурааслалуудаар хүрээ татсан байна. Хүрээ нь гэрчилгээний төрлөөс хамааран улаан, ногоон өнгөтэй байна.

Гэрчилгээний хүрээн доторх суурь өнгө нь хүрээний өнгөтэй ижил төрлийн байх боловч бүдэг, нэгэн жигд туяарсан байх ба гэрчилгээний бичвэр нь тод харагдахуйц байна. Төрийн соёмбо, гэрчилгээний дугаараас бусад бичвэрүүд нь тод хар өнгөтэй байна.

Гэрчилгээний дээд ирмэгээс 2,3 см, баруун зүүн талын ирмэгээс ижил зайд голлуулан алтан соёмбыг байрлуулсан байна. Соёмбоны өргөн нь 2 см байна.

Соёмбоны дор голлуулан "МОНГОЛ УЛС" гэж бичих ба үсгийн өндөр нь 5 мм байна.

"МОНГОЛ УЛС" гэсний дор гэрчилгээний төрлөөс хамааран "ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ", "ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ" гэж голлуулж бичих ба "ГЭРЧИЛГЭЭ" гэсэн үгийн өндөр 9 мм, бусад үгийн өндөр 3 мм байна.

Гэрчилгээний дараалсан хэвлэмэл дугаар нь 3 мм-ийн өндөртэй, тод улаан өнгөтэй байна.

Гэрчилгээний зүүн ирмэгээс 3,3 см, доод ирмэгээс 4,1 см зайд улсын бүртгэгчийн тэмдэг дарах зориулалттай 3,58 см-ийн диаметртай дугуй дүрсийг байрлуулсан байна.

Гэрчилгээний дээрх дүрс нь цагаан өнгийн дэвсгэртэй,

Гэрчилгээний ар тал нь ямар нэгэн бичвэргүй, хүрээтэйгээ харьцуулахад тэгш өнцгөөр байрласан усан хээтэй мэт боловч эдгээр хээнүүд нь түмэн наст хээ байна.

Гэрчилгээний ар талын зүүн доод хэсэгт гэрчилгээний дугаарыг хувиргасан бар кодтой байна. Гэрчилгээний хэвлэмэл дугаар нь неон гэрэлд өнгө нь хувирч харагдана.

Гэрчилгээний хүрээний дөрвөн булангийн хээ нь тодорхой давтамжтай долгионтуулсан зурааслалуудаас бүрдсэн байх бөгөөд энэ нь хувилах төхөөрөмжөөр хувилахад өнгө, хэлбэр дүрс нь алдагдана.

9. Газар өмчлөх эрхийн бүртгэлийн гэрчилгээ

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /цаашид "гэрчилгээ" гэх/ нь хуурамчаар үйлдэгдэхээс хамгаалагдсан нууцлал бүхий үнэт цаас байна.

Үнэт цаас нь тусгайлсан дугаартай байх ба дугаар нь үл давхцана.

Газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь ногоон өнгөтэй.

Гэрчилгээ нь бичгийн А4 цаасны хэмжээтэй, 150 гр/м²-ийн нягтралтай, босоо хэлбэртэй байна.

Гэрчилгээ нь төрөл тус бүрээрээ 9 орноос бүрдсэн араб тоо бүхий дараалсан хэвлэмэл дугаартай, хуудасгүй байна.

Гэрчилгээний 4 талын ирмэгээс 5 мм зайд тодорхой давтамжтай долгионтуулсан зурааслалуудаар хүрээ татсан байна. Хүрээ нь гэрчилгээний төрлөөс хамааран улаан, ногоон өнгөтэй байна.

Гэрчилгээний хүрээн доторх суурь өнгө нь хүрээний өнгөтэй ижил төрлийн байх боловч бүдэг, нэгэн жигд туяарсан байх ба гэрчилгээний бичвэр нь тод харагдахуйц байна. Төрийн соёмбо, гэрчилгээний дугаараас бусад бичвэрүүд нь тод хар өнгөтэй байна.

Гэрчилгээний дээд ирмэгээс 2,3 см, баруун зүүн талын ирмэгээс ижил зайд голлуулан алтан соёмбыг байрлуулсан байна. Соёмбоны өргөн нь 2 см байна.

Соёмбоны дор голлуулан "МОНГОЛ УЛС" гэж бичих ба үсгийн өндөр нь 5 мм байна. "МОНГОЛ УЛС" гэсний дор гэрчилгээний төрлөөс хамааран "ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ", "ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ" гэж голлуулж бичих ба "ГЭРЧИЛГЭЭ" гэсэн үгийн өндөр 9 мм, бусад үгийн өндөр 3 мм байна.

Гэрчилгээний дараалсан хэвлэмэл дугаар нь 3 мм-ийн өндөртэй, тод улаан өнгөтэй байна.

Гэрчилгээний зүүн ирмэгээс 3,3 см, доод ирмэгээс 4,1 см зайд улсын бүртгэгчийн тэмдэг дарах зориулалттай 3,58 см-ийн диаметртэй дугуй дүрсийг байрлуулсан байна.

Гэрчилгээний дээрх дүрс нь цагаан өнгийн дэвсгэртэй,

Гэрчилгээний ар тал нь ямар нэгэн бичвэргүй, хүрээтэйгээ харьцуулахад тэгш өнцгөөр байрласан усан хээтэй мэт боловч эдгээр хээнүүд нь түмэн наст хээ байна.

Гэрчилгээний ар талын зүүн доод хэсэгт гэрчилгээний дугаарыг хувиргасан бар кодтой байна. Гэрчилгээний хэвлэмэл дугаар нь неон гэрэлд өнгө нь хувирч харагдана.

Гэрчилгээний хүрээний дөрвөн булангийн хээ нь тодорхой давтамжтай долгионтуулсан зураасалуудаас бүрдсэн байх бөгөөд энэ нь хувилах төхөөрөмжөөр хувилахад өнгө, хэлбэр дүрс нь алдагдана.

10. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Хэмжээ: "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ" нь А4 /210х297мм/ хэмжээтэй.

Цаас нь 150гр/м²-ын нягтралтай, үнэт цаасны зориулалттай, хэт богино долгионы гэрэлд гэрэлтэхгүй, нүүр болон доод талд черниль, балаар бичилт хийхэд тохиромжтой, бэх уудаггүй, хурдан хатдаг, гөлгөр биш чанараа үл алдах, тамга тэмдгийн дардас тогтвортой байх бичгийн зориулалттай, хадгалах явцад арилахгүй, эдэлгээ даах чанартай байна.

Хүрээ хээ нь тасралтгүй үргэлжлэх нарийн зураасан шугамаар үнэт цаасны тусгай програм хангамжийн тусламжтайгаар тодорхой амплитуд бүхий үндэсний зохиомжит хээг бүтээсэн.

Булангийн хээнүүд нь үнэт цаасны зориулалттай тусгай програм хангамжийг ашиглан тасралтгүй үргэлжлэх нарийн зураасыг вектор графикийн аргаар үндэсний хээг цэцгэн хээтэй хослуулан хийсэн.

Хүрээ хээ нь цаасныхаа ирмэгээс 5мм дотогш хэвлэгдсэн болно.

Орчин үеийн хувилах төхөөрөмжийг ашиглах хуулбарлах, хувилах, сканердах үед зураасууд нь эвдэрч өөрийн хэв шинжээ алдана.

Үндсэн суурь хээ: Гэрчилгээний суурь хээний солбилцсон хоёр зураас нь үнэт цаасны зориулалтын программаар боловсруулалт хийж вектор графикийн аргаар Соёмбо билэгдлийг товойлгон урласан байх бөгөөд тодорхой хэсгүүдэд тогтмол бус хэмнэлтэйгээр нууцлалын түвшинд хэвлэгдсэн.

Гэрчилгээний дээд хэсгээр суурь хээ болгон тодорхой хэмнэлүүд бүхий өөр хоорондоо харилцан адилгүй өнцгүүдээр зурагдсан зургаан талт нарийн зураасаар бүтсэн хээг байрлуулсан. Үүний гол ач холбогдол нь тоон хэвлэлийн аргаар хуулбарлахад зурааснууд тасран цэг болж өөрчлөгддөг учир үнэт цаасны хамгаалалтанд өргөн хэрэглэгддэг байна.

Гэрчилгээний доод хэсгээр "МОНГОЛ УЛС, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ" гэсэн бичил бичвэрийг долгионтуулан байрлуулсан.

Монгол бичиг: Гэрчилгээний хүрээ хээн дээр голлон уйгаржин бичгээр "Монгол улс, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ" гэсэн бичвэрийг тасралтгүй үргэлжлэх зураасан хээн дунд байрлуулсан.

Холограм: Гэрчилгээний зүүн дээд хэсэгт байрлах алтан соёмбоны доор суурилж нарийн зурааснуудаар нууцлалын тодорхой хэмнэлтэйгээр хэвлэгдсэн суурь хээг байрлуулав. Алтан соёмбыг алтлаг холограмаар халуун даралтын аргаар буулгасан.

Гэрчилгээний дээд хэсэгт байрлах Соёмбо билэгдлийн хажууд "Монгол улс, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ" гэсэн үндсэн бичвэр нь програм хангамжийн аргыг ашиглан нарийн зурааснуудаас бүтсэн.

Нууцлал: Гэрчилгээний дэвсгэр соёмбон дээр дахин "Соёмбо" билэгдлийг нүдэнд харагдахгүйгээр хэвлэсэн. Энэхүү Соёмбо билэгдэл нь билэгдэл хэт богино долгионы 254нм-ийн UV гэрэлд ногооноор харагдана.

Гэрчилгээний баруун дээд хэсэгт 36мм-ийн диаметртэй тасралтгүй үргэлжлэх нарийн зураасаар үнэт цаасны програм хангамжийн аргаар бүтсэн Intaglio хэвлэлийн аргаар хэвлэсэн дардастай байна. Хуруунд төвийж мэдрэгдэнэ.

Арын суурь хээ: Гэрчилгээний арын суурь хээний тасралтгүй зураас нь үнэт цаасны зориулалтын програмаар боловсруулалт хийж вектор графикийн давтагдашгүй хэмнэлийг агуулсан ба түүн дээр алхан хээг хэмнэлийн зөрүүтэйгээр байрлуулсан. Мөн "МОНГОЛ УЛС, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ" гэсэн бичил бичвэрийг долгионтуулан байрлуулсан байна. Эдгээр харагдаж буй хээ болон бичил бичвэрүүд нь хуулбарлагдах болон хуурамчаар үйлдэх тохиолдолд шугамууд нь тасарч эвдрэх, сканердахын эсрэг хамгаалалт хийгдсэн байна.

Дугаарлалт: Гэрчилгээний урд талд тэмдэг бүр нь давтагдашгүй дараалах 9 оронтой дугаартай байна.

Баркод: Гэрчилгээний арын зүүн доод буланд Code39 үсгийн фондтой, 10рт-ийн өндөртэй баркод байрлах бөгөөд баркодны зураасны өндөр 11 мм, түүний доор 1 мм зайд 2 мм өндөртэй 9 оронтой цифр бичигдэх ба эхлэл төгсгөлд нь шалгахад зориулалж * тэмдэг хийсэн. Баркод нь унших төхөөрөмжөөр уншуулахад гэрчилгээний дугаар компьютерт шууд орохоор хийнэ.

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГУРАВДУГААР ХЭСЭГ
ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ



Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөл, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох баримт бичиг болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ГАРЧИГ

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
6. Барааны гарал үүслийн улс
7. Шалгалт, туршилт
8. Баглаа боодол
9. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
11. Гүйцэтгэлийн баталгаа
12. Даатгал
13. Чанарын баталгаа, баталгаат засвар
14. Төлбөр
15. Үнэ
16. Хуваарийг сунгах
17. Алданги оногдуулах
18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
21. Маргааныг шийдвэрлэх
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
24. Гэрээнд ашиглах хэл
25. Татвар, хураамж
26. Гарчиг
27. Үүргийн гүйцэтгэл





ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ



- 1. Нэр томьёо**
- 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
 - (б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
 - (в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.
 - (г) “бусад үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн тусалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
 - (д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
 - (е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.
 - (ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.
 - (з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- 2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах**
- 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.

- 1116-127152
 520472
 1116-127152
 520472
- 2.4. Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
- 3. Захиалгыг өөрчлөх**
- 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:
- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
- (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;
- (в) барааг хүргэх газар.
- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
- 4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- 5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах**
- 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
- 6. Барааны гарал үүслийн улс**
- 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
- 7. Шалгалт болон туршилт**
- 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний

- 
- туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
- 7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзах болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
- 8. Баглаа боодол**
- 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
- 9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIF /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 11. Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.



- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТООЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын фонд эсхүл, Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
 - 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
- 13. Чанарын баталгаа, баталгаат засвар**
 - 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
 - 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
 - 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
 - 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
 - 13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
 - 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
 - 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
 - 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
 - 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
 - 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
- 15. Үнэ**
 - 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон



үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендэрт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.

16. Хуваарийг сунгах

16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

- (а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
- (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
- (в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон вагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;
- (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.

Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.

16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.

17. Алданги оногдуулах

17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.

18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах

18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:


- (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
- (б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
- (в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;
- (г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд

гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.

- 18.2. 18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
19. **Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах** 19.1. Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.
20. **Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах** 20.1. Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй.⁴ Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
- 20.2. Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тэвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:
- (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
 - (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
21. **Маргааныг шийдвэрлэх** 21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
- 21.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
22. **Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал** 22.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
- 22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
23. **Гэрээний** 23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд

⁴Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

үүргийг шилжүүлэх	шилжүүлэхийг хориглоно.
24. Гэрээнд ашиглах хэл	<p>24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.</p> <p>24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.</p>
25. Татвар болон хураамж	25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
26. Гарчиг	26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
27. Үүргийн гүйцэтгэл	27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.



ДОЛООДУГААР БҮЛЭГ
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ



Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэх санамж

Гэрээний ерөнхий нөхцөлд дурдсан захиалагч, бараа зэрэг нэр томьёо тухайн гэрээнд юуг илэрхийлэхийг гэрээний тусгай нөхцөлд заадаг. Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэхдээ дараах зүйлсийг шалгана. Үүнд:

1. Гэрээний ерөнхий нөхцөлийн аль нэг зүйлд гэрээний тусгай нөхцөлийг ишилсэн бол холбогдох нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд заавал оруулна.
2. Тухайн гэрээний шаардлагаар гэрээний ерөнхий нөхцөлийг засварлах, илүү дэлгэрүүлэх тохиолдолд эдгээрийг гэрээний ерөнхий нөхцөлд бус тусгай нөхцөлд тусгана.
3. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтлана. Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлийн дугаарыг хаалтад хийж ишлэв.
4. ГТН-ийг хэрхэн бэлтгэх тухай зааврыг [] дөрвөлжин хаалтанд бичив. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч боловсруулна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 189 дүгээр тушаалын хавсралт



ДОЛООДУГААР БҮЛЭГ
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН - 1)	1.1.(д)	Захиалагч нь <i>Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар</i> .
2. Захиалгыг өөрчлөх (ГЕН - 3)	3.1	Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгаа хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд: а) Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх; б) Тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр; с) Барааг хүргэх газар;
3. Шалгалт туршилт (ГЕН - 7)	7.0	Захиалагчийн томилсон ажлын хэсэг нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолтод нийцсэн эсэхийг шалгаж туршиж хүлээн авна.
4. Баглаа боодол (ГЕН - 8)	8.0	Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан сав баглаа боодолтой байна.
5. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)	9.0	Барааг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргэх бөгөөд зарлагын падааныг дагалдуулан тоолж хүлээлгэж өгнө. Нийлүүлэгч барааг хүлээлцэх бүрт хүлээлгэн өгөхөд дагалдах баримтын дагуу хүлээлцэн, хүлээн авсан тухай баримт үйлдэн баталгаажуулсан байна. Үнэт цаас, маягт хүлээлгэн өгөхөд дагалдах баримт дараах зүйлээс бүрдэнэ. 1) Зарлагын падаан. 2) Бараа хүлээн авсан тухай акт. 3) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь.
	9.4	Монгол Улсын дотроос санал болгосон
6. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 11)	11.1	Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.
7. Даатгал (ГЕН - 12)	12.0	Даатгалын тусгай шаардлага байхгүй. Гэрээний хэрэгжилтийн явцад үүсэх аливаа даатгалтай холбоотой зардлыг гүйцэтгэгч хариуцана.
8. Баталгаат засвар (ГЕН-13)	13.0	Баталгаат засварын тусгай шаардлага Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд захиалагчийн бичгээр гаргасан шаардлагын дагуу үл маргах журмаар 14 хоногийн дотор хохирлыг барагдуулна.

9. Төлбөр (ГЕН - 14)	ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: ⁵
14.5	<p>Захиалагч Монгол Улсын дотроос санал болгосон ⁶ барааны төлбөрийг дараах журмын дагуу хийнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Урьдчилгаа төлбөр: Хэрэв тендерийн баримт бичигт заасан тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 30 хоногийн дотор, нэхэмжлэх болон барааг хүргэх хүртэл хүчинтэй, урьдчилгаа төлбөртэй тэнцэх дүнгтэй, тендерийн баримт бичигт заасан маягтаар эсвэл захиалагчид нийцэх өөр маягтаар, захиалагч хүлээн зөвшөөрөхүйц банкны баталгаа болон Засгийн газрын бондыг үндэслэн төлнө 2. Гүйцэтгэлийн төлбөр: Ирсэн барааны гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
10. Үнэ (ГЕН - 15)	Гэрээний хэрэгжилтийн явцад гэрээний үнийг тохируулахгүй тогтмол байлгана.
11. Алданги оногдуулах (ГЕН - 17) ⁶	17.1 Алданги оногдуулах хувь: <i>Хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлээгүй бараа, бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.5 хувь.</i> Алдангийн нийт дүн: <i>нийлүүлээгүй бараа, бүтээгдэхүүний үнийн дүнгийн 50%</i>
12. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0 Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
12.Хохирлыг барагдуулах	Үнэт цаас, маягтын дугаар буруу хэвлэгдсэн, дараалал алдагдсан, баглаа, боодол, материал, хэмжээ техникийн тодорхойлолт, стандартын болон чанарын шаардлага хангаагүй, хадгалалтын явцад хөгцөрч муудсан, гэмтсэн, ГТН-ийн 3-т заасан болон нийлүүлэгчээс шалтгаалах гологдол гарсан аливаа үед шаардлагад нийцүүлэхэд гарах алдагдлыг нийлүүлэгч бүрэн хариуцаж хохирлыг барагдуулна.
13.Сэлбэг	Нууцлалыг шалгах тоног төхөөрөмжийг нийлүүлж болно.



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

⁵ Энд дурдсан заалтууд болон хувиудыг зөвхөн жишээ болгож дурдсан бөгөөд /олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.
⁶ Монгол Улсын иргэний хууль

НАЙМДУГААР БҮЛЭГ
ГЭРЭЭНИЙ МАЯГТ



БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
_____ (Албан тушаал)	_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг


Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны сарын -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь нэр төрлийн барааг оны дугаар сарын -нээс оны дугаар сарын -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;

⁷ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.



6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь [Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт] (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс [баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]⁸ –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан [баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга

Огноо:

Хаяг:

⁸ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.



УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]



[Гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот [Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт] гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж [Захиалагчийн нэр]-ийн өмнө хариуцлага хүлээж [Баталгааны мөнгөн дүн][үсгээр]⁹-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

[Банк нэр] (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс [баталгааны дүн тоогоор, валют][дүн үсгээр, валют]¹⁰ –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэлхүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

⁹ Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

¹⁰ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017-04-24

Тендер шалгаруулалтын нэр: **Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын гэрчилгээ нийлүүлэх тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОӨУБЕГ/201703**



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар эрх бүхий тендерт оролцогчдоос “Гэрчилгээ, үнэмлэх” –г нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (**хүсвэл нэмэлт хувийг**) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000 /тавин мянган/** төгрөгөөр худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Борлуулалтын хэмжээ: 2016 оны борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгож байгаа үнийн дүнгийн 60 хувьтай тэнцүү буюу түүнээс дээш байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож байгаа үнийн дүнгийн 50 хувьтай тэнцүү буюу түүнээс дээш байх шаардлагатай.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил **/2015, 2016 оны жилийн эцсийн/**

Ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил **/2015, 2016/**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Үнэт цаасны тусгай зөвшөөрөлтэй компаниуд оролцоно.**

Тендерийн хамт **2 703 700** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 14 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 14 цаг 50** минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 5/2,
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр 1 давхар 105 тоот
Ц.Ганчимэг Утас/факс : 320907**



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/391

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2201045273 дугаартай хувийн хэрэг бүртгэлийг хүчингүй болгож, Г-2201004531 дугаартай хувийн хэрэг бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1.Иргэн Т.Отгонгэрэл /ОА75120209/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2201045273 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороо, Ногоон чулуут 4 дүгээр гудамжны 48/а тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг, Эрхийн улсын бүртгэлийн Г-2201004531 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороо, Ногоон чулуут 4 дүгээр гудамжны 48 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газартай нэгтгэж, бүртгүүлэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2201045273 дугаарыг хүчингүй болгож, Эрхийн улсын бүртгэлийн Г-2201004531 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2.Эрхийн улсын бүртгэлийн Г-2201045273, Г-2201004531 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000464634, 000443301 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2201045273 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хааж, Г-2201004531 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ц.Отгонжаргалд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Г.Цолмон нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



Хүндэтгэсэн
Хүндэтгэн
Хүндэтгэн
Хүндэтгэн



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/392

Улаанбаатар хот

Г Эрхийн улсын бүртгэлийн Г-2201011385, Г-2201011387 дугаартай хувийн хэрэг бүртгэлийг хүчингүй болгож, Г-2201011386 дугаартай хувийн хэрэг бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ю.Одбилэг /ЧЛ77011706/ нь өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-2201011385 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Хилчин 61 дүгээр гудамжны 7А тоот, эрхийн улсын бүртгэлийн Г-2201011387 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Хилчин 61 дүгээр гудамжны 8 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газруудыг эрхийн улсын бүртгэлийн Г-2201011386 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Хилчин 61 дүгээр гудамжны 7 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газартай нэгтгэж бүртгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2201011385, Г-2201011387 дугааруудыг хүчингүй болгож, эрхийн улсын бүртгэлийн Г-2201011386 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2201011385, Г-2201011387, Г-2201011386 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000046383, 000046385, 000046384 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2201011385, Г-2201011387 хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Г-2201011386 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Г.Ариунтуяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Г.Цолмон нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

P.СОДХҮҮ

Улаанбаатар хот
2017 оны 04 сарын 25 өдөр
Дугаар А/392



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/393

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. Иргэн Ц.Даваадорж /ИЕ68072977/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202002993 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо, Сургуулийн 15 дугаар гудамж, 240 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалтай газрын 72810 дугаартай;

1.2. Иргэн Ц.Даваадорж /ИЕ68072977/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2202010394 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо, Сургуулийн 15 дугаар гудамж, 240 тоот хувийн сууцны 150948 дугаартай;

1.3. Иргэн О.Цогбадрах /УХ90100711/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2202007922 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо, Сургуулийн 14 дүгээр гудамж, 296 тоот хувийн сууцны 138045 дугаартай;

1.4. Иргэн А.Төрхүү /ЦБ84022312/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2203027926 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол, Нарны зам, 60 дугаар байрны 118 тоот орон сууцны 000509893 дугаартай;

1.5. Иргэн Х.Гантуяа /ЖЭ85111902/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204009334 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Дүүргийн 10 дугаар гудамж, 524/Б тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалтай газрын 000083241 дугаартай;

1.6. Иргэн Д.Мөнхбат /ДК68111317/, Д.Оюунчимэг /ДЭ71022200/, М.Саранцэцэг /ДЮ92110909/, М.Саямандах /ДК94071903/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204008180 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Жанжин 29 дүгээр гудамж, 766 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалтай газрын 27826 лугаантай;

1.7. Иргэн С.Дөлгөөн /УО87050432/-ий өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204046602 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо, 13 дугаар хороолол /13371/, Намъянжугийн гудамж, 74 дүгээр байрны 76 тоот орон сууцны 000335939 дугаартай;

1.8. Иргэн Ц.Баярхүү /ХЕ69112079/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205017729 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 10 дугаар хороолол /16081/, ХД-62 дугаар байрны 1 тоот хувийн сууцны 000147413 дугаартай;

1.9. Иргэн П.Сайнбаяр /ЕЙ69071001/, Г.Энхбаатар /НВ63031613/, Э.Номиндарь /НВ91052505/, Э.Номундарь /НВ92072505/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205028818 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 10 дугаар хороолол, Төмөр замын 83 дугаар байр, 1 дүгээр орцны 16 тоот орон сууцны 0108858 дугаартай;

1.10. Иргэн Д.Цэцэгмаа /ТВ66020607/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205038430 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 7 дугаар хороо, Нарлаг хотхон /16094/, Ард Аюушийн өргөн чөлөө, 103 дугаар байрны 50 тоот орон сууцны 000138390 дугаартай;

1.11. Иргэн Н.Энхжаргал /ШБ66111571/, С.Оюун /ХЕ67100467/, Э.Хонгор /У393013114/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2206001263 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, 19 дүгээр хороолол, 2 дугаар байрны 14 тоот орон сууцны 000192439 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/394

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. Иргэн Х.Ганбат /ЧН55052570/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2201016472 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороо, Одонт 21 дүгээр гудамж, 127 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000081622 дугаартай;

1.2. Иргэн С.Энхтуяа /ЧВ68090863/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202008900 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Яргайтын 16 дугаар гудамж, 219/Б тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000051380 дугаартай;

1.3. Иргэн Т.Норовжав /ЧТ53101813/, Н.Зулхүү /УС81010208/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205034685 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Тэмүүлэл хотхон, 101 дүгээр байрны 96 тоот орон сууцны 000471045 дугаартай;

1.4. Иргэн Д.Балдорж /УГ40070178/, Б.Маам /УГ40072122/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2208001014 дугаарт бүртгэлтэй, Багануур дүүргийн 3 дугаар хороо, Наран хороолол, 33 дугаар байрны 4 тоот орон сууцны 000271545 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

26.10.17



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/395


Улаанбаатар хот

Зохиогчийн эрхийн
гэрчилгээнд өөрчлөлт оруулж
гэрчилгээг дахин олгох тухай

Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26.1.5 дахь заалт, бүтээлийн эрх эзэмшигчийн хүсэлт, эрх шилжүүлэх гэрээ болон бусад баримтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн 2284, 2370, 2369, 2368 дугаартай гэрчилгээний "Бүтээлийн өмчлөгч" гэсэн хэсэгт "Женьюс Кинг" ХХК гэснийг "Кэй Өү Эм Эм Жи Эл" ХХК гэж өөрчилж тус тус олгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/396

Улаанбаатар хот

Зохиогчийн эрхийн
гэрчилгээ олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26.1.5 дах заалт, зохиогчийн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн 8613 тоот дугаартай гэрчилгээг олгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/897

Улаанбаатар хот

Ашигтай загварыг улсын бүртгэлд
бүртгэж, гэрчилгээ олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Патентийн тухай хуулийн 12, 14 дүгээр зүйл, шинжээчийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шаардлага хангасан 20 ашигтай загварыг улсын бүртгэлд бүртгэж, эзэмшигчдэд гэрчилгээ олгосугай
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын дарга С.Урангэрэлд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт тус тус даалгасугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2017 оны 439 дугаар тушаалын хавсралт

№	Гэрчилгээний дугаар	Ашигтай загварын нэр	Анхдагч огноо	Гэрчилгээ эзэмшигч
1.	2685	Утаслаг уургаар баяжуулсан чанамал хиам үйлдвэрлэх арга	2016-12-22	А.Баянзул, Л.Дамдинсүрэн Н.Чимэгээ, Т.Болормаа
2.	2686	Малын тэжээлд нэмэлтээр хэрэглэгдэх целлюлаза ферментийн бэлдмэлийг үйлдвэрлэх арга	2017-01-12	З.Эрдэнэ, Х.Алтанцэцэг
3.	2687	Хүчит тэжээлийн жижигрэлтийн модуль тодорхойлох төхөөрөмж	2017-01-16	Б.Балдангомбо, Б.Ганбат, Б.Батмөнх, Г.Нямцэрэн, Г.Батбаяр, Д.Бямбацогт, Т.Хэрүүга
4.	2688	Хүрдэн төрлийн хэрчих аппаратны параметр судлах төхөөрөмж	2017-01-16	Б.Балдангомбо, Б.Ганбат, Б.Батмөнх, Г.Нямцэрэн, Г.Батбаяр, Д.Бямбацогт, Т.Хэрүүга
5.	2689	Цант төрлийн хэрчих аппаратны параметр судлах төхөөрөмж	2017-01-16	Б.Балдангомбо, Б.Ганбат, Б.Батмөнх, Г.Нямцэрэн, Г.Батбаяр, Д.Бямбацогт, Т.Хэрүүга
6.	2690	Тэжээл холих процесс судлах шнекэн төхөөрөмж	2017-01-16	Б.Балдангомбо, Б.Ганбат, Б.Батмөнх, Г.Нямцэрэн, Г.Батбаяр, Д.Бямбацогт, Т.Хэрүүга
7.	2691	Мах-өөхний гахайнд зориулсан багсармал тэжээл	2017-01-19	А.Отгонжаргал, Д.Сангажав, Н.Тогтохбаяр
8.	2692	Малын тэжээл хольж бэлтгэх зөөврийн төхөөрөмж	2017-02-03	Верса-Өрөм ХХК
9.	2693	Гэр сууцийг ус, чийг нэвчихээс хамгаалах давхарга	2017-02-07	Э.Булганхангай
10.	2694	Алтайн сонгины (<i>Allium altaicum</i> Pall) зигот үр хөврөлөөс бичил ургамал гарган авах арга	2017-02-14	Б.Буянчимэг, М.Жавзандулам, В.Энхчимэг
11.	2695	Улаан хальст сармис (<i>Allium sativum</i> L)-ны меристемийн өсгөврөөс бичил булцуу гарган авах арга	2017-02-14	Б.Буянчимэг, М.Жавзандулам, В.Энхчимэг
12.	2696	Хүрэн нүүрсний илчлэг чанарыг сайжруулах арга	2015-06-26	Б.Пүрэвсүрэн, Б.Бат-Өлзий, С.Жаргалмаа
13.	2697	Материал бутлах төхөөрөмж	2017-02-20	З.Чимэд-Осор
14.	2698	Хулан(<i>Equus hemionus</i>), цагаан зээр(<i>Procapra gutturosa</i>), хар сүүлт зээр (<i>Gazella subgutturosa</i>), монгол бөхөн (<i>Saiga tatarica mongolica</i>)-гийн тоо толгой, нөөцийг бодитоор тогтоох арга	2017-02-22	Г.Амарсанаа, Ц.Одбаяр
15.	2699	Цахилгаан эрчим хүчний чанарыг тодорхойлох арга	2017-03-06	П.Ариунболор
16.	2700	Тариалангийн талбайн хөрсийг хамгаалж чийг тогтоон барих арга	2017-03-16	ХААИС-ийн харъяа Ургамал газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн
17.	2701	Хайрсан далавчит хөнөөлт шавьжид өвчин үүсгэгч бактерийн нутгийн омог ВТА-М16	2017-03-22	Б.Нандин-Эрдэнэ, Д.Пүрэвдорж, С.Дэлгэрмаа
18.	2702	Агаарын орчны мэдээ цуглуулагч автомат төхөөрөмж	2017-03-28	Б.Дондогжамц, Б.Эрдэнэбат
19.	2703	Ахуйн болон үйлдвэрийн хогийг шатаан эрчим хүч гаргах арга	2017-03-28	Хилман групп ХХК



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/398

Улаанбаатар хот

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг
улсын бүртгэлд бүртгэж, патент олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Патентийн тухай хуулийн 13 дугаар зүйл, шинжээчийн дүгнэлтийг тут тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шаардлага хангасан 25 патентийг улсын бүртгэлд бүртгэж, эзэмшигчдэд патент олгосугай.
2. Шинэ бүтээлийн 12 патентийг нэгдүгээр хавсралтаар, бүтээгдэхүүний загварын 13 патентийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын дарга С.Урангэрэлд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт тус тус даалгасугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2017 оны 11 сар 14 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

№	Патентийн дугаар	Шинэ бүтээлийн нэр	Анхдагч огноо	Патент эзэмшигч
1.	4516	(R)-нифурател, түүнийг халдварын эмчилгээнд хэрэглэх болон (R) ба (S)-нифурател нийлэгжүүлэх арга	2014-11-07	POLICHEM S.A.
2.	4517	Автомат удирдлагатай гидравлик систем ба түүнийг агуулсан өрмийн машин	2015-07-09	Sandvik Intellectual Property AB
3.	4518	Нэг болон олон давхар барилга барихад зориулагдсан угсрагддаг хүчитгэсэн бетонон эд анги ба тэдгээрийг бүтээх иж бүрэн арга	2015-08-07	TERMIGAS S.P.A.
4.	4519	Ангиотензин хувиргагч энзимийг саатуулагч үйлчилгээтэй пептид, түүнийг ялгах болон хэрэглэх арга	2015-08-24	Монгол Улсын Их Сургууль
5.	4520	Ялган авах/салгах арга	2015-08-25	Shin-Etsu Chemical Co.,Ltd.
6.	4521	Шар сүүнээс лактоз ялгах арга	2015-11-27	Монгол Улсын Их Сургууль
7.	4522	Ашигласан пивоны дрожиос уураг ялгах арга болон түүний хэрэглээ	2015-11-27	Монгол Улсын Их Сургууль
8.	4523	Ашигласан пивоны дрожиос бета-глюканыг ялгах арга болон түүний хэрэглээ	2015-11-27	Монгол Улсын Их Сургууль
9.	4524	Ургамлын гаралтай ханиадны эсрэг бэлдмэл	2015-12-15	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн
10.	4525	Тэнгэрийн дүлий мөөг агуулсан шарх анагаах гель	2015-12-15	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн
11.	4526	Гетероунэрт нэгдлүүд ба тэдгээрийг допамин лигандийн адилаар хэрэглэх нь	2015-12-28	PFIZER INC
12.	4527	Давхар алгатай агаарын сэнс	2016-01-26	Б.Эрдэнэбат

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2017 оны 3-р дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



№	Патентийн дугаар	Бүтээгдэхүүний загварын нэр	Анхдагч огноо	Патент эзэмшигч
1.	2613	Бугатай дүрслэлтэй керамик чандарын сац, Маанийн үсэгтэй керамик чандарын сац, Сувраган дүрслэлтэй керамик чандарын сац /3 төрлийн загвар/	2016-02-15	Их Еслү ХХК
2.	2614	Буган дүрслэлтэй оршуулгын хайрцаг	2016-02-15	Их Еслү ХХК
3.	2615	Шоколадтай сүүний сав, баглааны загвар	2016-02-16	Монфрэш Сүү ХХК
4.	2616	УИХ1-ЯКНО загварын ил уурхайн өндөр хүчдэлийн бие даасан хорго	2016-02-19	БНЦМУ ХХК
5.	2617	Шахмал ногоон цайны сав баглаа боодол - загвар	2016-02-29	Тайван зул ХХК
6.	2618	GEREGET LOTTO хонжворт тоглоомын карт	2016-03-10	Б.Цондовдорж
7.	2619	Хармагны жимс савлах уут	2016-03-16	Б.Баярчимэг
8.	2620	Хармагны дарсны шошго	2016-03-16	Б.Баярчимэг
9.	2621	Хармагт цайны хайрцаг	2016-03-16	Б.Баярчимэг
10.	2622	Тунгалаг пүнтүүзний уутны загвар	2016-04-13	Буудайн Эгшиг ХХК
11.	2623	Бүхэл үрийн талхны цаасан уутны загвар	2016-05-09	Ворлд органик фүүдс ХХК
12.	2624	"Ла перла" гоо сайхны бүтээгдхүүн, шүдний ооны сав баглаа боодол	2016-10-27	Ла перла косметик ХХК
13.	2625	Дэвтрийн хавтас	2016-10-28	Таван богд менежмент ХХК



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар

1/399

Улаанбаатар хот

Бүтээл бүртгэж, зохиогчийн эрхийн
гэрчилгээ олгохыг зөвшөөрөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дахь заалт, Монгол Улсын “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн 26.1. 5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хянан шинжлэгдэж тогтоогдсон 94 бүтээлийн Зохиогчийн эрхийг баталгаажуулан бүртгэсүгэй.
2. Бүртгэгдсэн зохиогчийн эрхийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Эрх нь батламжлагдсан бүтээлүүдийн эздэд Зохиогчийн эрхийн гэрчилгээ олгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зохиогчийн эрхийн газрын дарга Э.Мягмардоржид үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



Оюуныгемч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын

2017 оны 3 сар 30-дугаар тушаал дэхь хавсралт

1116 127152

Зохиогчийн эрхийн гэрчилгээ олгох бүтээлийн жагсаалт

Дугаар	Эрх эзэмшигч	Улсын бүртгэлийн дугаар	Нэр	Бүтээлийн танилцуулга	Бүтээл туурьваж дууссан хугацаа	Хүлээн авсан огноо
1	Чулуунбаатар БАТЦЭЦЭГ	50-0008530	БАРИВЧ УРЛАХУЙ	БАРИВЧ УРЛАХУЙ Монгол орны соёлын хөгжилд түлхэц үзүүлэх бүтээл юм.	2016-04-09	2017-03-29
2	Шинэбаяр ЭГШИГЛЭН	50-0008531	БИДНИЙГ БУДААРАЙ	БИДНИЙГ БУДААРАЙ энэхүү ном нь 3-8 насны хүүхэд багачуудад будах зориулалттай юм.	2016-09-30	2017-03-29
3	Цэмбэл ОЮУНБАТ	50-0008532	ХҮНИЙ ХӨГЖИЛ ТӨЛӨВШИЛ	ХҮНИЙ ХӨГЖИЛ ТӨЛӨВШИЛ хичээл орж буй оюутан сурагчдад зориулсан гарын авлага ном.	2016-11-10	2017-03-29
4	НЕФРОМЕД	50-0008533	БИЕЭ ЭНХРИЙЛБЕ	БИЕЭ ЭНХРИЙЛБЕ ном нь бага насны хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилготой.	2017-03-11	2017-03-31
5	НЕФРОМЕД	50-0008534	БӨӨРНИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ	БӨӨРНИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ ном нь бөөрний өвчлөлөөс хэрхэн сэргийлэх талаар бөөр орлуулах аппаратанд орсон хүмүүст юунд анхаарах талаар мэдээлэл өгөх зорилготой.	2017-03-11	2017-03-31

6	Бямба ЦОГБЯАР	50-0008535	ХАРАНХҮЙ ХАД	ХАРАНХҮЙ ХАД уран сайхны КИНО	2016-10-11	2017-04-03
7	Лхамжав БАЯРМАА	50-0008536	ТӨРӨЛХИЙТЭН ХҮНИЙ ТӨЛӨВШИЛ	ТӨРӨЛХИЙТЭН ХҮНИЙ ТӨЛӨВШИЛ нь нийт хүмүүний төлөвлөлийн тухай ширээний НОМ.	2017-03-25	2017-04-03
8	Лхамжав ХҮДЭРЦЭЦЭГ	50-0008537	ЧИНГИС ХААНЫ АЛТАН ӨРГӨӨ ЦОГЦОЛБОР	ЧИНГИС ХААНЫ АЛТАН ӨРГӨӨ ЦОГЦОЛБОР-ыг Дорнод аймгийн Булган суманд бүтээн босгох юм.	2017-03-30	2017-04-03
9	Лхамжав БАТЖАВ	50-0008538	МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АСУУДАЛ	МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АСУУДАЛ ном.	2014-01-12	2017-04-03
10	Маналжав ШАГДАРСУРЭН	50-0008539	ЭЛЭГНИЙ ЭМГЭГ	ЭЛЭГНИЙ ЭМГЭГ тус номонд элэгний бүтэц, үйл ажиллагаа, уураг, нүүрс, ус өөх тосны солилцооноос эхлээд элэгний эмгэгүүдийн үед тохиолдох үндсэн болон хам шинжүүдийг оношлох зэрэг агуулгатай бичсэн.	2010-05-01	2017-04-03
11	Маналжав ШАГДАРСУРЭН	50-0008540	ЭЛЭГНИЙ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСИЙН ХООЛ ХҮНС 365 ХОНОГ	ЭЛЭГНИЙ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСИЙН ХООЛ ХҮНС 365 ХОНОГ нь Элэгний өвчнийг зөвхөн хоолоор эмчлэх жор аргуудыг маш тодорхой бичжээ.	2014-04-01	2017-04-03

12	Энхээ ДАВААДУЛАМ	50-0008541	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,СИСТЕМ	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,СИСТЕМ нь компьютерийн хэрэглээний программыг бие даан судалж буй бүх хүмүүст ашиглаж болохуйц бүтээл юм.	2017-01-02	2017-04-03
13	Энхээ ДАВААДУЛАМ	50-0008542	КОМПЬЮТЕР ГРАФИК ДҮРС БОЛОВСРУУЛАЛТ	КОМПЬЮТЕР ГРАФИК ДҮРС БОЛОВСРУУЛАЛТ нь оюутнууд,компьютер график,дүрс боловсруулалтын программыг бие даан судалж буй хүмүүст ашиглаж болохуйц бүтээл юм.	2016-01-20	2017-04-03
14	Болд САНЧИР	50-0008543	МАТЕМАТИК АНАЛИЗ	МАТЕМАТИК АНАЛИЗ ном нь ХААИС-ийн математик,програм хангамж хөтөлбөрт тусгайлан зориулагдан бичигдсэн.	2016-09-01	2017-04-03
15	Ишжамц ЛХАМ	50-0008544	ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ	ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ гарын авлагад орсон даалгаварууд нь идэвхтэй сургалтын аргад туулуурласан онцлогтой бүтээл юм.	2017-01-02	2017-04-03
16	Бямба САРАНТУЯА	50-0008545	САМАР ХАТАН	САМАР ХАТАН ном нь Монголын түүхэнд "Бага хаадын үе"гэгддэг 15-р зууны эхэн үеийн нэгэн жараны түүхийг харуулсан болно.	2017-02-04	2017-04-03
17	Батхүү БАЯРМӨНХ	50-0008546	БУРХАНЫ ШАВАР БАРИМАЛУУД	БУРХАНЫ ШАВАР БАРИМАЛУУД нь бэлэг дурсгалын бүтээл юм.	2013-11-07	2017-04-03

18	МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	50-0008547	НИЙГМИЙН ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ	НИЙГМИЙН ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ ном	2016-01-01	2017-04-05
19	МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	50-0008548	РАВЕНЫ ӨСӨХ ДАРААЛЛЫН ХҮСНЭГТЭН СОРИЛ	ӨСӨХ ДАРААЛЛЫН ХҮСНЭГТЭН СОРИЛ нь судалгааны заавар, судалгаа явуулах дүрэм горим, судалгааны үр дүнг боловруулах, сорилын түлхүүр, оюун ухааны хөгжлийн түвшинг тодорхойлох жишээ, хүүхдийн IQ оюуны коэффициентийг тодорхойлох жишиг хэмжээ зэргийг нэгтгэсэн болно	2010-01-01	2017-04-05
20	МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	50-0008549	ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ Д.ВЕКСЛЕРИЙН ТЕСТ	ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ Д.ВЕКСЛЕРИЙН ТЕСТ насанд хүрэгчдийн хувилбар	2014-05-01	2017-04-05
21	МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	50-0008550	ХҮҮХДИЙН АППЕРЦЕПЦИЙН ТЕСТ	ХҮҮХДИЙН АППЕРЦЕПЦИЙН ТЕСТ арга зүйн удирдамж	2014-05-01	2017-04-05

22	Сундуй БАДАРЧ	50-0008551	МОНГОЛ УЛСЫН МАХНЫ МАРКЕТИНГИЙН ИЖ БҮРДЭЛ	МОНГОЛ УЛСЫН МАХНЫ МАРКЕТИНГИЙН ИЖ БҮРДЭЛ нь эрдэм, шинжлэгээний судалгааны бүтээл юм.	2002-05-30	2017-04-05
23	Баасан БАТ- УНДРАЛ	50-0008552	ТОГТМОЛ БА ХУВЬСАХ ГҮЙДЛИЙН ШУГАМАН ХЭЛХЭЭНИЙ ШИЛЖИЛТИЙН ПРОЦЕСС	ТОГТМОЛ БА ХУВЬСАХ ГҮЙДЛИЙН ШУГАМАН ХЭЛХЭЭНИЙ ШИЛЖИЛТИЙН ПРОЦЕСС гэсэн нэртэй бүтээл нь тогтмол ба хувьсах гүйдлийн шилжилтийн процесс хэрхэн явагдах талаар өгүүлсэн.	2010-05-01	2017-04-05
24	Баасан БАТ- УНДРАЛ	50-0008553	ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ЧАДЛЫН АЛДАГДЛЫГ УРТ ШУГАМЫН ТЭГШИТГЭЛЭЭР ТОДОРХОЙЛОХ	ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ЧАДЛЫН АЛДАГДЛЫГ УРТ ШУГАМЫН ТЭГШИТГЭЛЭЭР ТОДОРХОЙЛОХ нь урт шугамын тэгшитгэлийг ашиглаж шугамын чадлын алдагдлыг тодорхойлох аргачлалыг тусгасан болно.	2013-02-15	2017-04-05
25	Хүрэлсүх ГАНСҮХ	50-0008554	ИРГЭНИЙ НИСЭХЭД АШИГЛАГДАЖ БУИ РАРІ СИСТЕМҮҮДИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА БОЛОН FOKKER 50, ATR 72, BOEING 737-800 АГААРЫН ХӨЛГҮҮДЭД ЗОРИУЛАН РАРІ СИСТЕМИЙГ БАЙРЛУУЛАХ ТООЦООЛОЛ	ИРГЭНИЙ НИСЭХЭД АШИГЛАГДАЖ БУИ РАРІ СИСТЕМҮҮДИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА БОЛОН FOKKER 50, ATR 72, BOEING 737-800 АГААРЫН ХӨЛГҮҮДЭД ЗОРИУЛАН РАРІ СИСТЕМИЙГ БАЙРЛУУЛАХ ТООЦООЛОЛ	2017-03-09	2017-04-05

26	Сундуй БАДАРЧ	50-0008555	МАРКЕТИНГ	МАРКЕТИНГ ном нь их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг юм.	2016-03-15	2017-04-05
27	Базарваань МӨНХТУЯА	50-0008556	ОХИН ТЭНГЭР	ОХИН ТЭНГЭР	2007-07-07	2017-04-05
28	Базарваань МӨНХТУЯА	50-0008557	СЭТГЭЛИЙН ХЯЗГААРТ	СЭТГЭЛИЙН ХЯЗГААРТ дүрст бүтээлийн эх зохиол.	2008-08-08	2017-04-05
29	Намсрай ЖАВЗМАА	50-0008558	Т.БАТААРЫН МУЗЕЙ	Т.БАТААРЫН МУЗЕЙ ном нь Үлэг гүрвэлийн төв музей байгуулагдан 2013-2014 онд хийгдсэн ажлыг багтаасан бүтээл юм.	2013-02-19	2017-04-05
30	Намсрай ЖАВЗМАА	50-0008559	ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН ТӨВ МУЗЕЙН КОНЦЕПЦИ	ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН ТӨВ МУЗЕЙН КОНЦЕПЦИ нь Үлэг гүрвэлийн төв музейн 2014-2025 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлно.	2013-02-19	2017-04-05
31	Лувсан БОЛД	50-0008560	INCREASE YOUR VOCABULARY	INCREASE YOUR VOCABULARY -энэхүү үгсийн санг баяжуулах нь бүтээл нийт 8 хичээлээс бүрдэж байна.	2017-01-24	2017-04-05
32	Төмөрболд ЗОЛБОО	50-0008561	КИНО МЭДЭЭЛЛИЙН ЛАВЛАХ ВЭБ САЙТ	КИНО МЭДЭЭЛЛИЙН ЛАВЛАХ ВЭБ САЙТ нь кино мэдээллийн вэб сайтуудыг нэгтгэж, тэдгээр сайтуудыг нэгтгэж, тэдгээр сайтуудын мэдээллийг нэг дороос хялбар, энгийн хэрэглэгчдэд үзүүлэх боломжийг хангах зорилготой юм.	2016-07-01	2017-04-05

33	Төмөрболд ЗОЛБОО	50-0008562	МОНГОЛ БИЧГЭЭР ЖИРГЭХ НИЙГМИЙН СҮЛЖЭЭ	МОНГОЛ БИЧГЭЭР ЖИРГЭХ НИЙГМИЙН СҮЛЖЭЭ программ хангамж юм.	2012-05-05	2017-04-05
34	Доржгочоо САРАНГЭРЭЛ	50-0008563	АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ПРОГРАМ	АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ПРОГРАМ нь ангийн байдлаар оновчтой, найдвартай шийдэхэд энэ программ туслах болно.	2013-12-12	2017-04-05
35	Чойжав БААТАР	50-0008564	МОНГОЛ ХУРАНДАА	МОНГОЛ ХУРАНДАА цуврал бүтээл юм.	2014-12-20	2017-04-06
36	Энхбат ОРГИЛ	50-0008565	SMART SOLUTION 1	SMART SOLUTION 1 программ нь караоке, дуучид, хөгжим, шүлгийн зохиогч нарт зориулсан бүтээл юм.	2017-01-09	2017-04-06
37	Гэрэлхүү АРИУНЖАРГАЛ	50-0008566	БИОЛОГИ ЭКОЛОГИЙН НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ	БИОЛОГИ ЭКОЛОГИЙН НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ ном нь оюутан, сурагч, биологийн эрдэм шинжилгээ судалгааны ажил хийдэг судлаач багш нар ашиглах бүрэн боломжтой.	2016-02-10	2017-04-06
38	Тэрбиш МАТСАРЖАВ	50-0008567	ӨРХИЙН АВТОМАТЖУУЛСАН ХҮЛЭМЖ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН МЭДЛЭГИЙН САН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ	ӨРХИЙН АВТОМАТЖУУЛСАН ХҮЛЭМЖ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН МЭДЛЭГИЙН САН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ бичмэл бүтээл	2017-02-17	2017-04-07

39	Цэдэвсүрэн ОЮУНСҮРЭН	50-0008568	PRESENTATION	PRESENTATION номонд англи хэлний ярианы чадварыг богино хугацаанд бие даан хөгжүүлэхэд танилцуулгын аргыг хэрхэн ашиглах тухай бичсэн болно.	2017-02-20	2017-04-07
40	Цэдэвсүрэн ОЮУНСҮРЭН	50-0008569	HOW TO MAKE PRESENTATION?	HOW TO MAKE PRESENTATION? номонд англи хэлний ярианы чадварыг богино хугацаанд бие даан хөгжүүлэхэд танилцуулгын аргыг хэрхэн ашиглах тухай бичсэн болно.	2017-02-20	2017-04-07
41	Маналжав ШАГДАРСҮРЭН	50-0008570	ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДАРЫН СУДАС БООХ ЭМЧИЛГЭЭ	ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДАРЫН СУДАС БООХ ЭМЧИЛГЭЭ ном.	2007-03-01	2017-04-07
42	Маналжав ШАГДАРСҮРЭН	50-0008571	СЭТГЭЛ ГЭГЭЭРЭЭСЭЙ	СЭТГЭЛ ГЭГЭЭРЭЭСЭЙ ном Монголын нэрт эрдэмтэд, зохиолч, яруу найрагч, төрийн зүтгэлтэнүүдийн бичсэн дурсамжуудыг товчлон оруулсан.	2003-04-01	2017-04-07
43	Пүрэвдорж МЯГМАРЦОГТ	50-0008572	СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ОЛОН ТӨРӨЛТ ДАСГАЛЫН ТӨХӨӨРЕМЖ ДЭЭР МӨЧДИЙН БҮТЭН БОЛОН ТАЛ СААТАЙ ӨВЧТӨН БУЛЧИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭЖ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ	СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ОЛОН ТӨРӨЛТ ДАСГАЛЫН ТӨХӨӨРЕМЖ ДЭЭР МӨЧДИЙН БҮТЭН БОЛОН ТАЛ СААТАЙ ӨВЧТӨН БУЛЧИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭЖ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ бичмэл бүтээл.	2017-01-01	2017-04-07

44	Бэгз САРАНГЭРЭЛ	50-0008573	БАРИЛГЫН ЭДИЙН ЗАСАГ Е-ХИЧЭЭЛ	БАРИЛГЫН ЭДИЙН ЗАСАГ Е-ХИЧЭЭЛ нь цахим лекц,семинар,бие даалтын ажлын удирдамж,нэмэлт материалаас бүрдэнэ.	2017-02-03	2017-04-07
45	Жамц МӨНХТӨР	50-0008574	ХҮСЛИЙН ЖИГУУР	ХҮСЛИЙН ЖИГУУР нь бодит амьдралд тулгуурлан бичсэн кино зохиол юм.	2016-12-12	2017-04-10
46	ФОРСЕЛАБ ХХК	50-0008575	БААТАР	БААТАР баримтат кино юм.	2017-02-14	2017-04-10
47	Балжаа ОЮУНЧИМЭГ	50-0008576	БАРИЛГЫН ҮНЭ БҮРДЭЛ	БАРИЛГЫН ҮНЭ БҮРДЭЛ ном нь үнэ бүрдэл,инженже технологийн мэргэжилтнийг мэргэжилтнийг бэлтгэж буй сургуулиудын оюутан сурагчид,эрдэмтэн судлаачид болон барилгын салбарын ажилтнуудад зориулсан.	2016-08-15	2017-04-10
48	Шагдарсүрэн ДОРЖПАГМА	50-0008577	МОНГОЛ БОЛОН ХЯТАД УЛСЫН ТЭЖЭЭЛИЙН, ЭРДЭНЭШИШИЙН СОРТУУДЫН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН ДҮН	МОНГОЛ БОЛОН ХЯТАД УЛСЫН ТЭЖЭЭЛИЙН ЭРДЭНЭШИШИЙН СОРТУУДЫН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН ДҮН бичмэл бүтээл юм.	2014-06-09	2017-04-10
49	Тавнай АРИУНАА	50-0008578	МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ ЭСГҮҮР, ЗАГВАРЧИЛГАА, ЭСГЭЖ ОЕХ ТЕХНОЛОГИ	МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ ЭСГҮҮР, ЗАГВАРЧИЛГАА, ЭСГЭЖ ОЕХ ТЕХНОЛОГИ зааварчилгааны ном юм.	2015-02-23	2017-04-10

50	Тавнай АРИУНАА	50-0008579	ҮЗЭМЧИН ЯСТНЫ УЛАМЖЛАЛТ ӨМСГӨЛ, ЗҮҮТГЭЛ, ЭД ХЭРЭГЛЭЛ	ҮЗЭМЧИН ЯСТНЫ УЛАМЖЛАЛТ ӨМСГӨЛ, ЗҮҮТГЭЛ, ЭД ХЭРЭГЛЭЛ	2014-07-03	2017-04-10
